



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 1/023

Хажуу шинэ үс

Газар эзэмших эрх
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Говь-Угтаал сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт (Сүмбэрийн хар толгой, Сүмбэрийн цагаан даравгай)-д байршилтай 5000м.кв (0.5га) өвөлжөө, хаваржааны зориулалттай хоёр газрын эзэмшигч Вандангийн Нямдорж (ЗВ58081112) нь 2021 оны 2 дугаар сарын 28-ний өдөр нас барсан. Иймд эхнэр Дашдондовын Оюунцэцэгт (ЗВ65040808) хоёр газрыг зориулалтаар шилжүүлж тус бүр 8 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй. Мөн Говь-Угтаал сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт (Аяган)-д байршилтай 5000м.кв (0.5га) өвөлжөө, хаваржааны зориулалттай газрын эзэмшигч Найдангийн Өнөрбат (ЗВ77111014) нь 2020оны 07 дугаар сарын 11-ний өдөр нас барсан. Иймд хүү Өнөрбатын Ганзоригт (ЗВ01322212) газрыг зориулалтаар шилжүүлж 9 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Б.Хорол)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд хор нөлөөлөлгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/04 дугаар захирамжийн хавсралтын 3,4 дэх хэсэг мөн газар эзэмших эрхийн 000531121, 000531122 тоот гэрчилгээнүүдийг мөн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/65 захирамжид заасан (Н.Өнөрбат)-д эзэмшүүлсэн хэсэг мөн газар эзэмших эрхийн 000020058 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



МӨНХ-АМГАЛАН

482201102